



ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ  
УЛААН ТУГИЙН ОДОНТ  
АРЬСНЫ ӨВЧИН СУДЛАЛЫН  
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН  
ТУШААЛ

2022 оны 01 сарын 03 өдөр

Дугаар 1/01

Улаанбаатар хот

АРЬСНЫ ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ  
Г ТӨВИЙН БҮТЭЦ, АЖИЛ АЛБАН ТУШААЛЫН  
ЖАГСААЛТ, ДОТООД ЖУРМЫГ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.3 дахь заалт, Төрийн албаны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.4 дэх заалт, Эмнэлгийн тусламж тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.6.6 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 103 дугаар зүйлийн 13.3 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 122 дугаар зүйлийн 122.1 дэх заалт, Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолын 7 болон 10 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус төвийн 2022 оны бүтцийг нэгдүгээр, бүтцэд хамаарах ажил, албан тушаалын жагсаалт, цалингийн шатлал, зэрэглэл, цалинг хоёрдугаар, 2022 онд ашиглах орны тоог гуравдугаар, хөдөлмөрийн дотоод журмыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.
2. Тушаал гарсантай холбогдуулан төвийн ерөнхий захирлын 2021 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/01 тоот тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.
3. Тушаалыг 2022 оны 01 дүгээр сарын 03-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.
4. Тушаалын хоёрдугаар хавсралтын дагуу цалинг тооцож олгохыг Санхүүгийн албаны дарга /Ш.Гантуяа/-д зөвшөөрсүгэй.
5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Үйл ажиллагаа эрхэлсэн дэд захирал /Т.Баярмаа/, Эмнэлзүй эрхэлсэн дэд захирал /Б.Батцэцэг/ нарт даалгасугай.
6. Тушаалыг нийт албан хаагчдад танилцуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хүний нөөцийн албаны дарга /Б.Пүрэвцэцэг/-т үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ /М.Ц.УРАНЧИМЭГ